



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Прокурорын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

СБА-2023/04/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Баруун-Урт сум

2023 он

Дарга,

тэргүүлэх аудитор: М.Нарантуяа

Утас: 70518396

Аудитын менежер: Г.Даваа

Утас: 70512123

Аудитор: А.Мөнхцэцэг

Утас: 70512127

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	
4. АУДИТЫН ТАЙЛАН	
4.1 Ерөнхий зүйл.....	
4.2 Материаллаг байдал	
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.5.1 Завсрын аудитын талаар.....	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	
5.1 Албан шаардлага.....	
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbeatar@audit.gov.mn

2023.02.17 № 40

танай _____-ны № _____-т

**СҮХБААТАР АЙМГИЙН ПРОКУРОРЫН
ГАЗРЫН ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА
Ц.ШҮРЭНЦЭЦЭГ ТАНАА**

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Прокурорын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Прокурорын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Сүхбаатар аймгийн Прокурорын газрын үйл ажиллагаа, тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээ, үйл явдал болон засаглах эрх бүхий этгээдүүдийн түвшин дэх харилцаатай холбоотой санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 4 зорилтын хүрээнд 36 арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилтийг "Дүүрэн хангалттай" үнэлэгдсэн байна.

D:/Bichig hereg/2023/A4 toot

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>10,281,481.88</u>	<u>10,001,722.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	10,281,481.88	10,001,722.00
354	Хангамжийн материал	10,281,481.88	10,001,722.00
35410	Бичиг хэргийн материал	3,423,539.88	3,521,230.00
35420	Аж ахуйн материал	3,618,942.00	3,241,492.00
35470	Бусад хангамжийн материал	3,239,000.00	3,239,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>234,122,534.37</u>	<u>272,921,112.80</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	234,122,534.37	272,921,112.80
392	Биет хөрөнгө	217,202,534.37	242,073,612.80
39201	Барилга, байгууламж, орон сууц	101,710,193.22	101,710,193.22
39202	Хуримтлагдсан элэгдэл	-14,520,086.56	-20,044,844.44
39203	Авто-тээврийн хэрэгсэл	121,700,000.00	75,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-86,580,555.50	-34,063,888.83
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	71,442,058.09	113,181,508.09
39206	Хуримтлагдсан элэгдэл	-15,351,575.72	-31,703,454.46
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	55,829,023.76	57,568,673.76
39208	Хуримтлагдсан элэгдэл	-17,026,522.92	-20,374,574.54
393	Биет бус хөрөнгө	16,920,000.00	30,847,500.00
39301	Програм хангамж	770,000.00	1,320,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-770,000.00	-192,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	16,920,000.00	29,720,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>244,404,016.25</u>	<u>282,922,834.80</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>244,404,016.25</u>	<u>282,922,834.80</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	244,404,016.25	282,922,834.80
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	215,330,272.02	228,130,272.02
51101	Өмч: - төрийн	215,330,272.02	228,130,272.02
512	Хуримтлагдсан үр дүн	21,655,532.78	47,374,351.33
51210	Өмнөх үеийн үр дүн	21,655,532.78	21,655,532.78
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	25,718,818.55
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,418,211.45	7,418,211.45
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>244,404,016.25</u>	<u>282,922,834.80</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	<u>731,367,188.00</u>	<u>758,265,450.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>28,888,488.00</u>	<u>58,763,450.00</u>
120	Нийтлэг татварын бус орлого	28,888,488.00	58,763,450.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	28,888,488.00	58,763,450.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	28,853,488.00	58,763,450.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>702,478,700.00</u>	<u>699,502,000.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	702,478,700.00	694,502,000.00

131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	702,478,700.00	694,502,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	5,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	5,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	699,771,443.15	721,503,803.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	699,771,443.15	721,503,803.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	633,747,039.14	652,818,282.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	426,673,237.21	467,965,571.56
210101	Үндсэн цалин	264,010,978.97	298,457,888.14
210102	Нэмэгдэл	141,582,258.24	124,211,298.22
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,080,000.00	21,970,000.00
210104	Урамшуулал	00.00	23,326,385.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,057,538.75	56,926,195.98
210201	Тэтгэврийн даатгал	37,476,221.68	38,795,157.04
210202	Тэтгэмжийн даатгал	4,176,829.26	4,557,959.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,307,863.48	3,619,487.71
210204	Ажилгүйдлийн даатгал	826,965.81	904,871.99
210205	Эрүүл мэндийн даатгал	8,269,658.52	9,048,719.45
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,441,096.95	17,925,201.58
210301	Гэрэл, цахилгаан	1,527,059.55	1,582,681.58
210302	Түлш, халаалт	12,909,397.40	12,815,880.00
210303	Цэвэр, бохир ус	1,804,640.00	2,438,640.00
210304	Байрны түрээс	1,200,000.00	1,088,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,373,427.20	27,171,030.03
210401	Бичиг хэрэг	9,957,079.46	9,455,449.46
210402	Тээвэр, шатахуун	9,120,460.00	9,778,020.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,166,017.74	2,889,810.57
210404	Ном, хэвлэл	409,200.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.00	906,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,540,670.00	3,771,000.00
210408	Бараа материал акталсны зардал	180,000.00	370,750.00
2105	Нормативт зардал	00.00	1,908,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,908,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	47,281,998.00	9,103,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	35,998.00	00.00
210604	Урсгал засвар	47,246,000.00	9,103,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,200,000.00	4,511,000.00
210702	Дотоод албан томилолт	2,200,000.00	4,511,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,885,918.00	7,948,289.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,589,276.00	7,600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	961,175.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	29,178.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	66,000.00	00.00
210807	Газрын төлбөр	84,600.00	148,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,833,823.03	59,359,994.07
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,553,600.00	7,142,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,300,000.00	8,400,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	27,980,223.03	43,817,694.07

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	66,024,404.01	68,685,521.73
2132	Бусад урсгал шилжүүлэг	63,140,000.00	2,260,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	62,640,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	2,260,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,884,404.01	66,425,521.73
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>31,595,744.85</u>	<u>36,761,646.05</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	11,042,827.50
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	11,042,827.50
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-11,042,827.50
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>31,595,744.85</u>	<u>25,718,818.55</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>702,513,700.00</u>	<u>699,502,000.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	35,000.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	35,000.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	35,000.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	702,478,700.00	699,502,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	702,478,700.00	694,502,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	702,478,700.00	694,502,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	5,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	5,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	<u>673,299,710.00</u>	<u>677,102,350.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	673,299,710.00	677,102,350.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	607,275,305.99	608,416,828.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	426,733,848.07	467,965,571.56
210101	Үндсэн цалин	270,440,017.32	310,113,287.14
210102	Нэмэгдэл	135,544,992.18	118,474,800.74
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,748,838.57	20,350,027.68
210104	Урамшуулал	00.00	19,027,456.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,996,927.89	56,926,195.98
210201	Тэтгэврийн даатгал	37,234,199.23	38,795,157.04
210202	Тэтгэмжийн даатгал	4,222,132.16	4,557,959.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,344,145.78	3,619,487.71
210204	Ажилгүйдлийн даатгал	835,986.39	904,871.99
210205	Эрүүл мэндийн даатгал	8,360,464.33	9,048,719.45
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,441,096.95	17,925,201.58
210301	Гэрэл, цахилгаан	1,540,799.55	1,582,681.58
210302	Түлш, халаалт	12,895,497.40	12,815,880.00
210303	Цэвэр, бохир ус	1,804,800.00	2,438,640.00
210304	Байрны түрээс	1,200,000.00	1,088,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,883,817.08	26,462,270.15
210401	Бичиг хэрэг	10,574,999.34	9,077,239.58
210402	Тээвэр, шатахуун	8,099,800.00	9,474,020.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,199,817.74	2,889,810.57
210404	Ном, хэвлэл	409,200.00	00.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.00	906,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,600,000.00	4,115,200.00
2105	Нормативт зардал	00.00	1,500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	47,311,998.00	8,913,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	35,998.00	00.00
210604	Урсгал засвар	47,276,000.00	8,913,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,200,000.00	3,531,000.00
210702	Дотоод албан томилолт	2,200,000.00	3,531,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,257,918.00	8,973,289.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,961,276.00	8,625,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	961,175.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	160,689.00	155,689.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	24,178.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	66,000.00	00.00
210807	Газрын төлбөр	84,600.00	148,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,449,700.00	16,220,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,799,700.00	7,820,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,650,000.00	8,400,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	66,024,404.01	68,685,521.73
2132	Бусад урсгал шилжүүлэг	63,140,000.00	2,260,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	62,640,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	2,260,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,884,404.01	66,425,521.73
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,884,404.01	66,425,521.73
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	29,213,990.00	22,399,650.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	29,213,990.00	22,399,650.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	29,213,990.00	22,399,650.00
2200	Дотоод эх үүсвэрээр	29,213,990.00	22,399,650.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	29,213,990.00	22,399,650.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-29,213,990.00	-22,399,650.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	215,330,272.02	7,811,021.45	-10,333,022.07	212,808,271.40
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	392,810.00	392,810.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	215,330,272.02	7,811,021.45	-9,940,212.07	213,201,081.40
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	31,595,744.85	31,595,744.85
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	215,330,272.02	7,418,211.45	21,655,532.78	244,404,016.25
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	215,330,272.02	7,418,211.45	21,655,532.78	244,404,016.25
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	215,330,272.02	7,418,211.45	21,655,532.78	244,404,016.25
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	12,800,000.00	00.00	00.00	12,800,000.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	25,718,818.55	25,718,818.55
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	228,130,272.02	7,418,211.45	47,374,351.33	282,922,834.80

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	694,502,000.00	628,076,478.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	694,502,000.00	628,076,478.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	692,242,000.00	625,816,478.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	516,959,400.00	467,965,571.56
210101	Үндсэн цалин	285,175,000.00	310,113,287.14
210102	Нэмэгдэл	191,111,400.00	118,474,800.74
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,772,000.00	20,350,027.68
210104	Урамшуулал	12,901,000.00	19,027,456.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,619,900.00	56,926,195.98
210201	Тэтгэврийн даатгал	45,451,900.00	38,795,157.04
210202	Тэтгэмжийн даатгал	4,792,000.00	4,557,959.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,833,600.00	3,619,487.71
210204	Ажилгүйдлийн даатгал	958,400.00	904,871.99
210205	Эрүүл мэндийн даатгал	9,584,000.00	9,048,719.45
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,930,300.00	17,925,201.58
210301	Гэрэл, цахилгаан	1,651,900.00	1,582,681.58
210302	Түлш, халаалт	12,906,900.00	12,815,880.00
210303	Цэвэр, бохир ус	2,327,500.00	2,438,640.00
210304	Байрны түрээс	1,044,000.00	1,088,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,462,300.00	26,462,270.15
210401	Бичиг хэрэг	9,049,300.00	9,077,239.58
210402	Тээвэр, шатахуун	9,300,000.00	9,474,020.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,002,000.00	2,889,810.57
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал	951,000.00	906,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,160,000.00	4,115,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,913,000.00	28,912,650.00
210602	Тавилга	15,800,000.00	15,799,650.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,705,800.00	6,973,289.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,354,000.00	6,625,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	159,200.00	155,689.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20620300.00	15620300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,800,000.00	10,800,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	694,502,000.00	628,076,478.27
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	694,502,000.00	628,076,478.27
131001	Улсын төсвөөс санхүүжих	694,502,000.00	628,076,478.27

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3000000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000.00

II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5000000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Прокурорын Тамгын газар “Үйл ажиллагаанд инновац нэвтрүүлэх, гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах, прокурор, ажилтны ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, чадварлаг прокурор, ажилтныг сайшаан дэмжих, прокурор, ажилтны суралцах орчин, нөхцөлийг бүрдүүлж ажиллах зорилт дэвшүүлэн Прокурорыг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь туслах, прокурорын газрын бие даасан байдал, прокурорын хараат бус байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Прокурорын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Прокурорын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 38,518.8 мянган төгрөгөөр буюу 15.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган.төг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Бараа материал	10,281.5	10,001.7	-279.7
Үндсэн хөрөнгө	234,122.5	272,921.1	38,798.5
Нийт хөрөнгө	244,404.0	282,922.8	38,518.8
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	244,404.0	282,922.8	38,518.8
	244,404.0	282,922.8	38,518.8

Бараа материалын дансны үлдэгдэл 10,001.7 мянган төгрөг болж 279.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 282,922.8 мянган төгрөг болж 38,518.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Төсвийн хөрөнгөөр 22,399.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга худалдан авсан, Улсын ерөнхий прокурорын газраас 35,139.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлж, дахин үнэлсэн 23,320.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 12,800.0 мянган төгрөгийн газар үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, элэгдэл нь дууссан 68.6 мянган, бусад газарт шилжүүлсэн 14,060.0 мянган төгрөгийн хөрөнгө данснаас хасагдсан нь нөлөөлжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 26,898.3 мянган төгрөг буюу 3.7 хувиар нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлогын данс байна. Энэ нь 304.0 мянган төгрөгийн бараа материал, 58,459.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсан нь нөлөөлжээ.

Нийт зардал өмнөх оноос 21,732.3 мянган төгрөг буюу 3.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин хөлс болон урамшуулал, урсгал зардал, зэрэг зардлууд байна.

Энэ нь 1 орон тоо, төрийн үйлчилгээний ажилчдын цалингийн шатлал нэмэгдсэн нь нөлөөлжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 717,251.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 717,251.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 120,071.5 мянган төгрөгөөр бууруулж, 597,180.1 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн тодотголоор тус байгууллагын төсвийг тайлант хугацаанд 4-5 удаа өөрчлөн 97,321.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 694,502.0 мянган төгрөгийн төсөв баталж улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 694,502.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 628,076.5 мянган төгрөг зарцуулж 66,425.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 628,076.5 мянган төгрөг буюу 90.4 хувьтай байгаа нь цалин хөлс болон унаа хоол бусад нөхөн олговрын зардал 49,993.8 мянга, АО-оос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 7,693.7 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 4,732.5 мянга, бараа үйлчилгээний зардал 5,000.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101- Үндсэн үйл ажиллагаа	686,142.0	619,716.4	66,425.6	90.3%
2	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал дэмжлэг	2,260.0	2,260.0	-	100%
3	82315-Байцаан шийтгэх ажиллагаа	6,100.0	6,100.0	-	100%
НИЙТ		694,502.0	628,076.4	66,425.6	90.3%

Үндсэн үйл ажиллагааны арга хэмжээний зардлын гүйцэтгэл 90.3 хувьтай хэрэгжсэн нь батлагдсан бүтэц орон тоо дутуугаас (1 орон тоо дутуу) цалин, нэмэгдэл урамшууллын зардал 66,425.6 мянган төгрөгөөр хэмнэгдэж дээд шатны төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд ГХУС арга хэмжээний зардалд ИТХ-аас 2,000.0 мянган, ЗДТГ-аас байрны түрээсийн зардалд 3,000.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулжээ.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Прокурорын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-наас 2022 оны 2 дугаар сарын 25-ны хооронд Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Мөнхцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Прокурорын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дүгээр сарын 24-ны өдрийн 1/49 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд нийт ажил гүйлгээний ихэнх хувийг зардлын гүйлгээ эзэлдэг бөгөөд төсвийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байдлыг татвар төлөгч, иргэд илүү анхаардаг учир материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 699,771.4 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 13,995.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 11,196.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1 , 15.2.3 -т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд уг зардлууд 515.2-1,760.0 мянган төгрөгөөр өссөн байна. Тухайлбал: цэвэр,бохир усны зардал 633.8 мянга, тээвэр шатахууны зардал 1,374.2 мянга, нормын хувцас, зөөлөн эдлэл 1,500.0 мянга, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал 1,400.0 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал 1,760.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Бараа бүтээгдэхүүний үнэ болон шатах тослох материалын үнэ өмнөх оноос нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих 149 мэдээллээс хугацаа болоогүй 2, хугацаандаа оруулсан 143 мэдээлэл, 6 мэдээллийн 343,222.9 мянган төгрөгийн хугацаа хоцроож мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Прокурорын тамгын газарт завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчлийг арилгах 3 зөвлөмжөөс 2 бүрэн хэрэгжиж 1 зөвлөмж хэрэгжээгүй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	3	0		2	66.6
Нийт дүн					

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сүхбаатар аймгийн Прокурорын газрын тайлант оны үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл, ажил гүйлгээ болон санхүүгийн тайланг тасалбар болгож гаргасан өдрөөс хойших үйл явдлыг шинжилж үзэхэд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар Шилэн дансны цахим хуудаст 343,222.9 мянган төгрөгийн 6 мэдээллийг мэдээлээгүй, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, тээвэр шатахууны зарцуулалтыг жолоочийн тооцооны хуудсанд холбогдох зааврын дагуу үнэн зөв хөтлөөгүй зэрэг зөрчил илэрсэнд албан шаардлага хүргүүлсэн.

5.1 Албан шаардлага

- Шилэн дансны цахим хуудаст 343,222.9 мянган төгрөгийн 6 мэдээллийг мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.3-т заасан “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам” -ыг зөрчсөн байна.
- Цахим дэлгүүрт байршсан бараанаас худалдан авалт хийлгүй, төсвийн хөрөнгөөр 6600,0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж бэлтгэсэн.
- Тээвэр шатахууны зарцуулалтыг жолоочийн тооцооны хуудсанд холбогдох зааврын дагуу үнэн зөв хөтөлж, ямар ажлаар хаашаа явсныг тодорхой бичиж толилуулаагүй зөрчил дутагдал илэрлээ.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 / тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх /, 6 дугаар зүйлийн 6.4.5 /цалингийн зардлаас бусад таван мянган төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;/, Төрийн хэмнэлтийн тухай 14 дүгээр зүйлийн 14.4 / Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно /, ТБОНӨБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.13 дахь / Ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авах бараа, үйлчилгээг цахим дэлгүүрт байршуулснаас өөр этгээдээс худалдан авахыг хориглоно./, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;/ заалтуудын зөрчсөн байна.

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Үүнээс			Зөвлөмж		
	Тоо	Дүн	Төлбөрийн акт	Албан шаардлага	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн сайтад оруулах мэдээллээс таван мянган төгрөгөөс дээш үнийн дүнгийн урсгал санхүүжилтийн мэдээлээгүй	1	0			1	0		
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй	1	6,600.0			1	6,600.0		
Тээвэр шатахууны зарцуулалтыг жолоочийн тооцооны хуудсанд холбогдох зааврын дагуу үнэн зөв хөтөлж, ямар ажлаар хаашаа явсныг тодорхой бичиж толилуулаагүй	1	0			1			
Дүн	2	6,600.0			2	6,600.0		
Нийт дүн	3	6,600.0			3	6,600.0		